

СУДАЛГААНЫ АЖЛЫН СЭДЭВ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ

М.Хаш-Эрдэнэ

ДХИС-ийн Удирдлагын академийн 2022-7081 дүгээр дамжааны суралцагч,

Товч агуулга: Судалгааны ажлын сэдэв боловсруулах, томъёолох үйл явцыг эрдэмтэд үндсэн ажлын ихэнх хувийг эзэлдэг гэж үзэн ач холбогдол өгдөг. Яагаад гэвэл энэ хэсэгт судалгааны ажлыг багцлан хураангуйлсан гол зүйлүүд бичигддэг. Иймээс энэхүү ажлаараа, судалгаа шинжилгээний ажил, түүнийг гүйцэтгэх үе шат, судалгааны ажлын удиртгал хэсгийг хэрхэн бичих талаар судалж, дүгнэлээ.

Түлхүүр үгс: Судалгааны ажил, зорилго, зорилт, таамаглал, үе шат, үндэслэл, шаардлага, арга зүй, ач холбогдол

Оршил. Судалгааны ажил гэдэг нь шинэ мэдлэгийг нээх, тайлбарлах, хэрэгжүүлэх зорилгоор тодорхой сэдэв, асуудал, асуудал, үзэгдлийн талаар системтэй судалгаа хийх, судлах, лавлахыг хэлнэ.

Шинжлэх ухаан, нийгэм, хүмүүнлэгийн ухаан, технологи, бизнес зэрэг янз бүрийн салбарт судалгаа хийж, одоо байгаа мэдлэгийг өргөжүүлэх, онолыг баталгаажуулах, шинэ үзэл баримтлал боловсруулах эсвэл практик асуудлыг шийдвэрлэх зорилготойгоор хийгддэг.

Нэг. Судалгаа, шинжилгээний ажлын тухай ойлголт

Судалгаа шинжилгээний ажил гэдэг нь янз бүрийн хүчин зүйл (фактор)-ээс хамааран судалж байгаа зүйл (объект)-ийн өөрчлөгдөх шинэ үзэгдэл, зүй тогтлыг илрүүлж, тэрхүү зүй тогтлыг цаашид амьдрал практикт ашиглаж болох зорилго бүхий үйл ажиллагаа юм¹.

Судалгаа шинжилгээний ажил нь тавьсан зорилт, түүнийг шийдвэрлэх арга, үр дүнг шийдвэрлэх салбараас хамаарч онолын, онол-туршилтын,

туршилтын, суурь, хавсрал, тухайн, иж бүрэн гэж ангилагдана. Үүнд:

Онолын судалгаа гэдэг нь судалж байгаа зүйлийг математик юм уу, төсөөлөн бодох (логик) аргаар судлахад үндэслэгддэг. Онолын судалгааны мөн чанар нь аливаа үзэгдэл, юмсын хувирч өөрчлөгдөх механизм, байгаа байдлыг нийгэм, эдийн засаг, байгалийн хуулиудад тулгуурлан тайлбарлах, уг үзэгдэл юмсын тухай маш тодорхой ойлголттой болж, шинэ үзэгдэл юмсын мөн чанарыг урьдчилан хэлж чаддаг болоход оршино. Шинжлэх ухааны үндэслэлтэй онол нь үнэн байдлын тусгаж, урьд өмнө хуримтлуулсан бодит зүй тогтлыг нэгтгэж байдаг.

Онол туршилтын судалгаа нь онолын хувьд судалсан зүйлээ практик дээр туршин шалгаж, өөрөөр хэлбэл, онолын судалгааны үр дүнг бодит загвар биет байдал дээр шалган туршиж, үнэмшил бий болгох явдал мөн. Энэ нь онолын судалгааны үр дүн практикаар нотлогдож буй хэрэг юм.

Туршилтын судалгаа нь Эрдэм шинжилгээний байгууллага, их дээ сургууль, үйлдвэр завод, газар

¹ Авдай Ч., Энхтуяа Д., "Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй", УБ., 2007. 6 дахь тал

тариалан, мал аж ахуйн нөхцөлд биет юм уу, тодорхой загвар дээр хийх судалгаа юм. Туршилтын судалгааны зорилго нь бодит биет зүйлийг танин мэдэх, онолын төсөөлөл бий болгох, байгаа байдлыг үнэ мөнөөр нь ялган батлахад чиглэдэг. Аливаа судалгааны ажил туршилтын судалгаагаар ихэвчлэн эхэлдэг. Туршилтын судалгааны явцад нэг зүйлийг олон дахин хэмжих, туршилтыг дахин давтан хийхэд үзэгдэл юмсын мөн чанар танигдаж, түүнд үнэн зөв тайлбар өгөх, үр дүнг математик статистикийн аргаар батлах, улмаар, зохимжит болон оновчтой хэмжээг тодорхойлж тогтоох чадвар эзэмшинэ.

Суурь судалгаа_Энэ нь зарчмын хувьд шинэ хууль нээх, асуудал шийдвэрлэх, онол бий болгоход чиглэгдэнэ. Суурь судалгааны үр дүнгийн үндсэнд шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлд өндөр үр ашиг өгч чадах хавсрал зорилтууд шийдвэрлэгдэж байдаг. Суурь судалгаа нь шинжлэх ухаан, технологийн дэвшлийн хамгийн гол, ирээдүйтэй чиглэлийг тодорхойлж өгдөг онцлогтой.

Хавсарга судалгаа. Үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж, технологийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, үр дүнг дээшлүүлэх зорилгоор тодорхой салбарт хийгдэх судалгааны ажил юм. Хавсрал судалгаа нь онолын судалгааны үндсэнд хийгдэж байдаг. Өөрөөр хэлбэл, судлаач оюутан, магистрант, докторант, багш, эрдэм шинжилгээний ажилтан бүхэн онолын

тодорхой мэдлэгтэй, шинжлэх ухаанаар батлагдсан хуулиудыг мэддэг байх ёстой.

Тухайн судалгаа_Энэ нь нэг юм уу хоорондоо ижил төсөөтэй объектыг судлахад чиглэнэ. Тухайн юм уу хэсэгчилсэн судалгааны үр дүн нь цаг уур байгаль орчны болон бодит нөхцөл байдалтай уялдан хэлбэлзэх утгатай байх боловч, бодит байдлыг үнэн мөнөөр нь тайлбарлах, ингэснээр иж бүрэн судалгааны салшгүй хэсэг болох ёстой билээ.

Иж бүрэн судалгаа нь аливаа үзэгдэл юмс, байгаль орчин зэрэг бүх төрлийн объектыг тал талаас нь судалгааны янз бүрийн арга багаж, төхөөрөмж хэрэглэж судлах явдал юм. Иж бүрэн судалгаа нь янз бүрийн газар орчинд өөр, өөр хугацаанд хийгдэж болно.


Судалгаа шинжилгээний тодорхой чиглэлээр хийгдэж байгаа ажил дээр дурдсан судалгааны ажлын нэг юм уу хэд хэдэн төрлөөр хийгдэнэ.

Хоёр. Судалгааны ажил хийж гүйцэтгэх үе шат

Судалгааны ажил бол товчоор, таны эрхэлж байгаа ажилд, эсвэл, ажиллаж байгаа салбарт ямар асуудал тулгарч байна, түүнийг шийдвэрлэхийн тулд ямар үйл ажиллагаа явуулаад, ямар үр дүнд хүрсэн бэ? гэдэг үйл явц байдаг.

Иймээс олон улсын эрдэмтэд судалгааны ажил хийх үе шатын олон талаас нь тайлбарласан байгааг харьцуулан авч үзлээ (Зураг 1.2.)

Зураг 1. Судалгааны ажил хийж гүйцэтгэх үе шат¹



Зураг 2. Судалгааны ажил хийж гүйцэтгэх үе шат²



Дээрх загваруудаас үүдэн аливаа судалгаа шинжилгээний ажил нь тодорхой зорилго, төлөвлөгөө, үе шаттай явагддаг тул судлаач судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ дараах дэс дарааллыг баримталбал зохино. Үүнд:

1. Судалгаа шинжилгээний ажлын сэдвийг сонгож, зорилгоо тогтоох
2. Судлах гэж байгаа зүйлийнхээ одоогийн байдлыг судалж, зохих дүгнэлт өгсөн байх
3. Дүгнэлт дээрээ үндэслээд уг объектын хувьд чухам юуг ялган авч судлах гэж байгаа, өөрөөр хэлбэл, зорилтоо тодорхойлох
4. Судалгааны аргачлал боловсруулах

5. Судалгаа явуулах
6. Судалгааны үр дүнг боловсруулж дүн шинжилгээ хийх
7. Судалгааны үр дүнгээр дүгнэлт зөвлөмж гаргах
8. Судалгааны үр дүнг бичлэгийн хэлбэрт юм уу зураг төсөл бусад хэлбэрт оруулах

Судалгааны ажлыг уншиж судалсан ном бүтээлээс олж мэдсэн, туршиж нээсэн мэдлэг дээрээ тулгуурлан өөрийн хийсэн задлан шинжилгээ, харьцуулалт, дүгнэлт, шинэ санаа, шүүмжлэлт байр сууриа илэрхийлэн бичнэ.

Судалгааны ажил бичих явцад ном зохиол, эх материалтай бие даан ажиллах, судалгааны материалуудад

¹ <https://www.wikihow.com/Write-a-Research-Paper>

² <https://libguides.elmira.edu/research>

шүүмжлэлтэй хандах, үзэгдэл үйл явдалд онол арга зүйн үүднээс зөв үнэлэлт өгөх, түүний шалтгаан, үр дагаврын холбоог тогтоох, дүгнэлт өгөх зэрэг чадвар эзэмшинэ.

Сонгож авсан сэдвийн талаар өргөн мэдлэгтэй болох төдийгүй үндсэн асуудлыг логик дараалалтай бичиж өөрийн санаа бодлоо ул үндэстэй дэвшүүлэх, илэрхийлэх чадварыг эзэмшинэ.

Сонгосон сэдвээ удирдагчийн зөвлөгөөнд үндэслэн бичих ба сэдэв сонгохдоо судалгаа шинжилгээний ажил болгон үргэлжлүүлж болох тодорхой асуудлыг авах нь чухал юм. Судалгааны ажлыг хийж гүйцэтгэх үе шатыг судалгаа хийж байгаа цар хүрээ, дэвшүүлсэн зорилго, зорилт зэргийг харгалзан тодорхойлж, дараах байдлаар тогтооно.

Судалгааны ажлын бичиж боловсруулах нь:

- Бэлтгэл үе шат:
- Судалгааны үе шат:
- Төгсгөл үе шат:

Бэлтгэл үе шат

а/ Тухайн ажлаар ямар асуудлыг ямар хүрээнд шийдвэрлэхээ тодорхойлох: Судалгааны ажлын сэдвийг сонгохдоо урьдчилан холбогдох материал уншиж судлах хэрэгтэй бөгөөд эндээс ямар нэгэн сонирхолтой, эдрээтэй асуудал, сэдвийн санааг олж авах болно. Энэхүү асуудал судалгааны ажил болж байгаа шалтгаан, түүнийг хэрхэн ямар түвшинд шийдвэрлэх боломжтой(зорилго) урьдчилсан байдлаар тодорхойлно.

б/ Судалгааны ажлынхаа ажиллах төлөвлөгөө боловсруулах: Судалгааны ажил гүйцэтгэхдээ хэдий хугацаанд холбогдох ном зохиол уншиж судлах, сонгосон сэдвийн судалгааны материал цуглуулах, мэдээллийн боловсруулалт хийж гүйцэтгэх, Судалгааны ажлын явц болон гүйцэтгэлийг удирдагч багшид үзүүлэн зөвлөгөө авч ажиллах зэргийг тодорхой график гарган ажиллах нь судалгааны

ажлаа зохих түвшинд бичиж хамгаалахад илүү тус дөхөмтэй болно.

в/ Сонгосон сэдэвтэй холбоотой онол, арга зүйн материал уншиж судлан, мэдээлэл цуглуулах: Судалгааны ажлын сэдэвтэй холбоотой ном сурах бичиг, лекц, гарын авлага, эрдэм шинжилгээ судалгааны материал, өгүүлэл, хууль эрх зүйн актууд, интернэт болон бусад эх сурвалжуудыг нарийвчлан судалж мэдээлэл цуглуулах. Энд хэрэгцээтэй болон сонирхолтой гэж үзсэн материалаа тэмдэглэл, хайчилбар хийх зэргээр цуглуулж байна.

г/ Судалгаа хийх аргачлал боловсруулах: Сэдэвтэй холбоотой материал уншиж судлах үед өөрөө нэмж хийх судалгаа, туршилт, ажлын санаа аяндаа гарч ирэх бөгөөд тэрхүү ажлынхаа ерөнхий зорилго, хаана ямар зорилтыг шийдвэрлэж болохыг тодорхойлох нь туршилт судалгааны ажлын аргачлал болно.

д/ Боловсруулсан аргачлалаа удирдагч багшид үзүүлж зөвлөгөө авах: Өөрийн боловсруулсан аргачлалаа удирдагч багшдаа үзүүлэн тайлбарлаж зөвлөгөө авах нь Судалгааны ажлыг эхнээс нь зөв гүйцэд, чанартай хийх, цаг хэмнэх зэрэгт нөлөөтэй. Өөрөөр хэлбэл Судалгааны ажлынхаа агуулгыг гаргаж батлуулна. Хэрэв Судалгааны ажлын агуулгыг хэт олон бүлэг сэдэвтэй боловсруулбал сэдвээсээ халих, зарим асуудлыг дахин давтах зэрэг алдаа дутагдал бий болж энэ нь ,анхаарал төвлөрөхгүй, судалгааг логик байдлаар шинжлэх боломжгүй гэх мэт сөрөг үр дагаварт хүрэхийг анхаарууштай.

Судалгааны үе шат

а/ Судалгааны ажлын арга зүйн хувьд: Энэ үе шатны ажлыг хийж гүйцэтгэхдээ судалгааны шаардлагатай материалыг бүртгэх, цуглуулах арга хэлбэрээ тодорхойлон төлөвлөсний дагуу цуглуулсан материалдаа боловсруулалт хийн тухай бүр удирдагч багшаасаа зөвлөгөө авч ажиллах нь зүйтэй байдаг. Судалгааны ажлын явцад түгээмэл хэрэглэгддэг анализ, синтез, харьцуулах, индукц, дедукц,

ангилан системчлэх болон математик, статистикийн аргуудаас гадна сүүлийн үед өргөн ашиглагдах болсон эконометрикийн аргуудыг ашиглах нь цаашдын судалгааны ажлын арга барилд илүү эерэг нөлөөтэй юм. Судалгааны ажил хийхэд анхаарах нийтлэг зүйл бол таны судалж буй юмс үзэгдэл байнга өөрчлөгдөж байдаг гэдгийг харгалзах явдал ба судалгааны аргыг хэр оновчтой сонгож хэрэглэснээс ажлын амжилт шалтгаалдаг. Аргаа сонгохдоо судалж буй асуудлын хүрээ, онцлог, дэвшүүлсэн зорилт, таамаглал зэргийг харгалзан үзэх ба тэдгээр аргуудыг хослуулан хэрэглэх нь зөв.

б/ Судалгааны ажлыг хийж гүйцэтгэх: Өөрийн сонгож авсан сэдэвтэй холбоотой ном зохиолоос гадна эрдэмтэн мэргэдийн бичиж туурвисан эрдэм шинжилгээний өгүүлэл, зөвлөмж, илтгэл, диссертацийн болон дипломын ажил, заавар журам гэх мэт өргөн хүрээтэй мэдээллийн эх сурвалжтай ажиллана. Шаардлагатай ном зохиолыг сонгон авахдаа багшийн зөвлөсөн зүйлс танд баримжаа болохыг анхаарна уу. Ном зохиол судалж тэмдэглэл хөтлөхдөө тулгуур ухагдахуун болон гол үзэл санааг тэмдэглэн авах ба тэмдэглэл хийхдээ өөрийн үгээр уншсан зүйлийн утга санааг бичиж авах эсвэл уншиж байгаа зүйлийг зохиогчийн үгээр тэмдэглэж(эшлэл авах) болно. Тухайлбал:

- Зохиолтой ерөнхийд нь танилцаж гарчиг, бүлэг хуудсыг гүйлгэн харах

- Зохиолоос өөрт хэрэгтэй хэсгийг ол авах

- Чухал гэсэн зүйл дээр анхаарлаа төвлөрүүлэн тогтож унших

- Уншиж буй зүйлийн товч тэмдэглэл хийх

- Уншсан зүйлээ эргэн харж системчлэх

- Уншиж буй зүйлээ уншсан зүйлтэй харьцуулах

- Уншиж буй зүйлээ тунгаан бодох, шүүмжлэлтэй хандах, үнэлэлт дүгнэлт өгөх

- Зохиолыг уншиж байх үед төрсөн санаа бодол, дүгнэлтийг тэмдэглэж авах

в/ Судалгааны материалд боловсруулалт хийх: Уншиж судалсан болон туршилт судалгааны материалыг оновчтой зөв боловсруулснаар ажлын үр дүн сайжрах тул материалдаа дээр тусгагдсан аргуудаар боловсруулалт хийх шаардлагатай. Тухайлбал, ямар тоон үзүүлэлтийг дундажлах, алийг нь ямар үзүүлэлтээр илэрхийлэх, үнэлэлт дүгнэлт тоон үзүүлэлтийн алийг нь ямар диаграммаар харуулбал зохистой зэргийг багшийн зөвлөгөө болон өөрийн олж үзсэн судалгаа шинжилгээний материалаас санаа авч ажиллах нь зохистой. Жишээ нь хувиар тооцож байгаа үзүүлэлтийн тухайд хүснэгтийн толгойн хэсэгт “%” тэмдэглэгээг хэмжих нэгжээр сонгосон бол үзүүлэлтийн тоон утгын ард %-ийг тавих шаардлагагүй.

Төгсгөл үе шат

Энэ шатанд уншиж судалсан, цуглуулсан материал, эх сурвалжид шинжилгээ судалгаа хийсний дараа Судалгааны ажлын журамд заасан стандартын дагуу бичиж боловсруулан хамгаалахад бэлтгэх ажиллагаа хамаарна. Үүнд:

а/ Судалгааны ажлын эх бэлтгэх: Өөрийн уншиж судалсан материалдаа тулгуурлан Судалгааны ажлын эхийг анхны хувилбараар буюу үндсэн хэсгийн эх бэлэн болгох. Бэлтгэсэн эхээ дахин нягталж үзсэний дараа агуулга, сэдэв, судалгаа хоорондын уялдаа, дэвшүүлсэн зорилго хэр хангагдсан зэргийг тооцон үзэх хэрэгтэй.

б/ Агуулгын дагуу ерөнхий загвар(анхны хувилбараар) гаргах: удирдагчаар батлуулсан Судалгааны ажлын агуулгын дагуу бэлтгэгдсэн эх болон бусад хэсэг болох оршил, дүгнэлт, санал, ном зүй, хавсралт зэргийн бүрдлийг нэг бүрчлэн шалгаж нэгтгэн авч үзээд боловсруулалтыг эцэслэн хийх.

в/ Хэвлэхэд бэлтгэх: энэ нь хамгийн эцсийн үйл ажиллагаа бөгөөд боловсруулсан Судалгааны ажлын эхийн стандарт хангалтыг сайтар хянаж үзээд хэвлэж бэлтгэвэл зохилтой.

Дээрх дарааллаар Судалгааны ажлаа хийж боловсруулбал цаг хэмнэх төдийгүй таны ажлын гүйцэтгэл сайтай болох, улмаар хамгаалалт ч гэсэн өөрийн хөдөлмөр шингэсэн тул амжилттай байх болно.

Гурав. Удиртгал хэсгийг хэрхэн бичих вэ?

Судалгааны ажлын удиртгал хэсэг маш чухал ач холбогдолтой байдаг. Яагаад гэвэл энэ хэсэг судалгааны ажлыг багцлан хураангуйлсан гол зүйлүүд бичигддэг.

Сэдвийг сонгосон үндэслэл, шаардлага: Удиртгал хэсгийн хамгийн эхэнд сэдвийг сонгосон үндэслэл, шаардлага, асуудлыг тодорхойлон гаргадаг. Энэ хэсгийг ерөнхий асуудлаас тусгай руу чиглэсэн хэлбэрээр бичих үү, тусгай асуудлаас ерөнхий рүү чиглэсэн хэлбэрээр бичих үү гэдгийг судлаач өөрөө сонгон бичнэ. Аль ч хэлбэрээр бичсэн бай дараах шалгуурыг бүрэн хангасан байх шаардлагатай. Үүнд:

- Судалгааг хийх болсон шалтгааныг тодорхой бичсэн байх
- Практикт гарч буй асуудал, проблемыг олж харж томьёолсон байх
- Тулгарч буй асуудал, проблемыг тоо баримтаар баталгаажуулсан байх
- Судалгааны үндэслэлээс судалгааны зорилго тодорхойлогддогийг харгалзах
- Тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд судлаачийн оруулах хувь нэмэр юу болохыг тодорхойлох

Судалгааны зорилго, асуулт

Удиртгал хэсгийн дараагийн гол хөндөх ёстой зүйл нь судалгааны зорилго, асуулт байдаг. Аливаа судалгаа шинжилгээний ажил олон улсын болон өөрийн улс орон, нутаг дэвсгэрийн тухайн хэсэг үйлдвэрлэлийн өмнө тавигдаж байгаа аливаа асуудлыг судалж шийдвэрлэх зорилгыг агуулна.

Энэхүү зорилгыг ганц удаагийн судалгаагаар шийдвэрлэхгүй. Өөрөөр хэлбэл судалгааны ажлын эцсийн үр дүн буюу зорилгод хүрэхийн тулд судлаач бүр тодорхой зорилтыг өмнөө тавьж, үнэн зөв шийдвэрлэх хэрэгтэй байдаг. Энэ нь тухайн ажлын сэдэвтэй бүрэн уялдана. Судалгааны ажлын зорилго нь завсрын юмуу эцсийн үр дүнд хүрэхээр байж болно.

Судалгааны зорилго товч, тодорхой нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, олон утга санаа агуулаагүй, оновчтой, давхар утга агуулаагүй байх нь зүйтэй. Харин судалгааны зорилтын хувьд судалгааны зорилгод хүрэхийн тулд ямар ямар алхмыг хийж гүйцэтгэх тухайгаа нарийвчлан тодорхойлох хэрэгтэй. Жишээ нь:

Судалгааны ажлын зорилго

Гамшгийн үеийн санхүүгийн удирдлагад шинжилгээ хийж боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход судалгааны ажлын гол зорилго оршино.

Судалгааны ажлын зорилтууд

Судалгааны ажлын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан зорилтуудыг тавьсан болно. Үүнд:

- 1.Сэдэвтэй холбоотой гол гол ойлголтуудын тодорхойлолтыг өгөх
- 2.Гамшгийн үеийн санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлж ирсэн гадаад орнуудын туршлагыг судлах
- 3.Гамшгийн үеийн санхүүгийн удирдлагад шинжилгээ хийх
- 4.Судалгааны үндсэн дээр гамшгийн үеийн санхүүгийн асуудлыг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлуудыг тодорхойлох
- 5.Гамшгийн үеийн санхүүгийн удирдлагыг боловсронгуй болгох зарим арга замыг тодорхойлох

Судалгааны асуулт нь аль болох нарийвчилсан, ерөнхий бус, давхар утга ороогүй байна. Жишээ:

- Бордоог хэрэглэх нь ургамлын ургацыг нэмэгдүүлэх үү?
- Чинээлэг малчин өрх илүү хол зайд нүүдэллэдэг үү?

Онолын үндэс, тулгуур концепц

Тухайн асуудал аль хир судлагдсан байна вэ гэдгийг томъёолохдоо судлаач эрдэмтдийн судалгааны ажил ямар нэртэй, хэдэн онд, хаана бичигдсэнийг бичихээс гадна тухайн судлаач асуудлыг аль талаас судалсан болохыг дүгнэх нь цаашдын судалгааны ажлыг тодорхой болгоход тус дөхөм болдог. Дараах асуултуудад бүрэн дүүрэн хариулсан байхыг шаарддаг. Үүнд:

Судалгааны ажлын гол онол, концепциуд нь юу байна?

Нотолсон судалгаанууд юу байна?

Миний судалгаанд тохирох уу?

Онолын үндэслэл болж чадах уу?

Мөн өөрийн судлагдахуунтай холбож, дүгнэлт хийн, судалгааны таамаглал руу хандуулан бичих хэрэгтэй.

Судлах гэж байгаа зүйлийнхээ одоогийн байдлыг судлахдаа аль болох бүрэн мэдээлэл авч, үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэгдэнэ. Судалгаа шинжилгээний ажил бүхэн урьд өмнө эрдэмтэн, судлаачдаас тухайн чиглэлээр хийж, гүйцэтгэсэн эрлэм шинжилгээний ажлын үргэлжлэл болж байдаг. Ийм учраас тавьсан зорилгод хүрэхийн тулд тухайн чиглэлээр дэлхий нийтийн хэмжээнд юмуу тухайн чиглэлээр судалгаа явуулдаг гадаадын ба өөрийн орны эрдэмтдийн судалгааны ажлын үр дүн, судалж байгаа байдлын одоогийн байдлыг нарийн судалж, үнэлэлт дүгнэлт өгнө. Үүний тулд судалгааны ажилтай төсөөтэй мэдээлэл, шинжлэх ухаан, техникийн зохиол бүтээл, техникийн норм дүрмийн баримт бичиг, стандартыг цуглуулж судлах, патентын судалгаа явуулах, өөрийн явуулах судалгааны чиглэлтэй холбоотойгоор урьд өмнө нь хийгдсэн судалгааны материалыг цуглуулж, тэмдэглэл хөтлөх, ижил төсөөтэй зорилтыг шийдвэрлэсэн бололцоотой чиглэлүүдийг бүртгэн авч, харьцуулсан дүгнэлт судалгаа гаргах зэрэг олон үйл ажиллагаа гүйцэтгэнэ.

Таамаглал дэвшүүлэх

Судалгааны ажлын холбогдох онол, концепцид тулгуурласан, өмнө хийгдсэн судалгааны үр дүнд тулгуурласан, мэдээлэл мэдлэгт тулгуурласан дүрслэлийн болон шалтгаан үр дагаврын утгатай судалгааны асуулттай холбоотой, шалгаж тестлэгдэх боломжтой байдлаар бичигдсэн байна.

Судалгааны арга зүй хэсгийг:

Үндсэн судалгааны ажлаас судалгааны талбараа тодорхойлсон байдал

Өгөгдөл цуглуулах аргыг дүрсэлсэн байх

Цуглуулсан өгөгдлөө тодорхойлж бичих

Тогтмол болон хувьсах утга, тэдгээрийг хэмжих аргыг тайлбарлах
Шинжилгээ хийх аргаа тайлбарлах байдлаар бичнэ.

Гарах үр дүн, судалгааны ач холбогдол

Судалгааны ажлаас урьдчилан харж байгаа үр дүнгээ дүрслэн бичсэн байна. Судалгааны үр дүнгээ судалгааны онцлогтой уялдуулж болно. Судалгааны ажлын үр дүнгээс үндэслэн судалгааны ач холбогдлыг шинжлэх ухаан болон практик талаасаа тодорхойлон гаргаж бичих нь зүйтэй.

Дүгнэлт

Судалгаа шинжилгээний ажил нь тавьсан зорилт, түүнд хүрэх арга, үр дүнг шийдвэрлэх салбараас хамаарч онолын, онол-туршилтын, туршилтын, суурь, хавсарга, иж бүрэн гэж ангилагдана.

Судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ тодорхой дэс дарааллыг баримталбалу арга зүйн дадал эзэмшиж, ур чадвартай болно гэж дүгнэж байна. Иймээс дарааллыг тоймлон жагсаалаа. Үүнд:

- Судалгаа шинжилгээний ажлын сэдвийг сонгож, зорилгоо тогтоох;

- Судлах гэж байгаа зүйлийнхээ одоогийн байдлыг судалж, зохих дүгнэлт өгсөн байх;

- Дүгнэлт дээрээ үндэслээд уг объектын хувьд чухам юуг ялган авч судлах гэж байгаа, өөрөөр хэлбэл, зорилтоо тодорхойлох;

- Судалгааны аргачлал боловсруулах;

- Судалгаа явуулах;

- Судалгааны үр дүнг боловсруулж дүн шинжилгээ хийх;

- Судалгааны үр дүнгээр дүгнэлт зөвлөмж гаргах;

- Судалгааны үр дүнг бичлэгийн хэлбэрт юм уу зураг төсөл бусад хэлбэрт оруулах;

Санал

- Судалгааны ажлын сэдвийг боловсруулахаас эхлэн дэс дарааллыг баримтлах;

- Судалж буй судалгааны онцлог, ангиллаас хамаарч дүн шинжилгээ хийх аргачлал сонгох. зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

- Авдай Ч., Энхтуяа Д., “Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй”, УБ., 2007.

- Тунгалаг У., “Судалгааны санал боловсруулах арга зүйн товч”, УБ., 2017.

- Мандах их сургууль., “Судалгааны ажил бичих зөвлөмж”, УБ., 2018.

- Монгол Улсын их сургууль., “Судалгааны дизайн боловсруулах арга зүй”, УБ., 2015.

- Ц.Баатарцогт Нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй сурах бичиг УБ, 2012 он

- Ш.Ичинхорлоо Диссертацийн ажлын арга судлалын үндэс УБ,2020 он

- Ранжит Кумар Судалгааны арга зүй дөрөв дахь хэвлэл